



“УБТЗ” ХНН-ИЙН ЭРДЭНЭТ ӨРТӨӨНД

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДУГНЭЛТ

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, II хороо, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: 70112333, Факс: (976-11) 31-23-15
E-mail: info@mrt.gov.mn, <http://www.mrt.gov.mn>

2016.03.14 № 038-07-068/06

САЛБАР ТӨМӨР ЗАМЫН ОБЪЕКТЫН
ГЭРЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ

“Төрийн хяналт шалгалтын тухай хууль”-ийн 5², 10 дугаар зүйл, “Төмөр замын тээврийн тухай хууль”-ийн 12 дугаар зүйлийн 12.4.6 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.5.2 дахь заалт, Зам, тээврийн сайдын 2012 оны 121 тоот тушаалаар батлагдсан “Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журмыг тус тус үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

ТОДОРХОЙЛОХ НЬ:

Эрдэнэт өртөөн дэх “Жаст ойл” ХХК-ийн шатахууны агуулахын салбар замд тавигдах стандартын шаардлага, Техник ашиглалтын дүрмийн холбогдох шаардлагууд бүрэн хангагдсан байна.

Мөн ашиглалт, үйл ажиллагаатай холбоотой дараах баримт бичгүүд хийгдсэн байна.

Үүнд:

1. Салбар замын хэвгийн шалгалт хийсэн дагуу аясын болон дэвсгэр зургийг тусгай зөвшөөрөл, гэрчилгээтэй эрх бүхий байгууллага болох “УБТЗ” ХНН-ийн Техникийн бодлого, зураг төслийн төвд 2011 онд хийлгэсэн байна.

2. Салбар замд суурилуулсан тоног төхөөрөмж, шингэн түлшний агуулахад холбогдох чиглэлийн байгууллага тогтмол хяналт тавьж байна.

3. Тус байгууллага нь салбар төмөр зам арчлалтын гэрээг эрх бүхий байгууллага болох “УБТЗ” ХНН-ийн Замын 6-р ангитай 2016 онд байгуулсан байна.

ДҮГНЭХ НЬ:

Иймд “УБТЗ” ХНН-ийн Эрдэнэт өртөөнд “Жаст ойл” ХХК-ийн салбар төмөр замд 2016 онд “Объектын гэрчилгээ” олгох хүртэл төмөр замын тээврийн үйлчилгээ үзүүлэхэд татгалзах зүйлгүй болно.

Дүгнэлт бичсэн:

- ЗТХХ-ийн Төмөр замын тээврийн
Замын хяналтын мэргэжилтэн,
Улсын байцаагч



С.МАЙДАР